



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 22 өдөр

Дугаар А/451

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Боловсрол, шинжлэх ухааны яамны 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 2/5227 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянгол дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төвийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын бүтэц, орон тоо болон албан тушаалтны тодорхойлолт, ажлын чиг үүргийн хэрэгжилт, сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ажлыг удирдамжийн дагуу зохион байгуулсугай.

2.Тус арга хэмжээг хэрэгжүүлэх Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс (С.Мөнхзаяа)-т үүрэг болгосугай.


3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Ажлын хэсгийн дарга Д.Жаргалсүрэнд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.СУМЪЯАБААТАР

Баянгол дүүргийн Засаг даргын
2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн
А/451 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	Д.Жаргалсүрэн	(Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан төслийн удирдагч)
Гишүүд:	Б.Мөнгөнхуяг	(Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)
	С.Мөнхзаяа	(Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга)
	М.Даваасүрэн	(Хүний нөөц, ёс зүй хариуцсан мэргэжилтэн)
	Б.Мөрөн	Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)
	Г.Баялагмаа	(Нийгмийн хөгжлийн хэлтсийн Боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн)
	Б.Оюунбат	(Дотоод аудитын албаны ахлах мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга:	З.Энхгэрэл	(Боловсролын хэлтсийн дарга)

Баянгол дүүргийн Засаг даргын
2021 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн
А/451 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН УДИРДАМЖ

2021 оны 10 дугаар сарын 19

Улаанбаатар хот

Нэг.Зорилго

Баянгол дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төвийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын бүтэц, орон тооны давхардал, албан тушаалын чиг үүрэгт нийцэж байгаа эсэх, байгууллагын ажилтан, албан хаагчдын сахилга хариуцлагад хяналт тавих, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхэд оршино.

Хоёр.Хамрах хүрээ

Баянгол дүүргийн Албан бус-Насан туршийн төв

Гурав.Зохион байгуулах хугацаа

2021 оны 11 дүгээр сарын 03-наас 05-ны өдрийн хооронд

Дөрөв.Хяналтын чиглэл

Ажлын хэсэг нь байгууллагын үндсэн үйл ажиллагаа болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд хяналт тавих, батлагдсан бүтэц, орон тооны норматив болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн давхардалд хяналт тавих, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ. Үүнд:

1.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

2.Батлагдсан бүтэц, орон тооны дагуу ажиллаж байгаа эсэх, сул орон тоог зохих журмын дагуу нээлттэй ил тод сонгон шалгаруулалт явуулдаг эсэх;

3.Ажлын байрны сахилга хариуцлага, дэг журам, цаг ашиглалтын бүртгэлд хяналт тавих;

4.Албан хаагчдын хувийн хэрэг, боловсролын бичиг баримттай танилцах; (албан тушаалын тодорхойлолтод нийцэж байгаа эсэх)

5.Албан хаагчдыг ажлаас чөлөөлсөн болон томилсон тушаалын хуулийн үндэслэлийг судлах; (Тушаал болон холбогдох материалтай танилцах)

6.Ажил олгогчоос ажилтнуудтай байгуулсан хөдөлмөрийн гэрээтэй танилцаж, дүгнэх;

7.Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

8.Албан хаагчдад мэргэжлийн зэрэг, ур чадварын нэмэгдэл; ажлын үр дүнгийн урамшууллыг зохих журмын олгодог эсэхтэй танилцаж, дүгнэлт гаргах;

9.Иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлт;

10. Албан бичгийн шийдвэрлэлт;
11. Байгууллагын өөрийн орлого бүрдүүлэлт болон батлагдсан төсвийн хүрээнд захиран зарцуулж байгаа эсэхэд хяналт тавих;
12. Өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих;

Тав.Үр дүн

Ажлын хэсэг нь байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, зөвлөмж дүгнэлтийг байгууллагын удирдлагад танилцуулах ба цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг ажлын 14 хоногийн дотор Засаг даргын зөвлөлийн хурлаар танилцуулна. Хяналтын чиглэлийн дагуу илэрсэн зөрчлийг арилгах чиглэлээр холбогдох хэлтэс, албадаас зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.